

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Бүх дэлхийн эмэгтэйчүүдийн төлөө залбирцгаая

Арван хоёрдугаар сар аль хэдийн ирж, энэ он дуусах дөхжээ. Эргэн харвал, энэ жил Бурханы биднийг хайрласан Түүний энэрэл нигүүлсэлд талархал, магтаалаар дүүрэн байлаа. Тэрээр бидэнд ‘уулзалт’-ын явцад хамтдаа бүтээж, ганцаараа хийж чадахгүй зүйлээ биелүүлэх боломжийг өгсөн, олон улсын залбирлаар дамжуулан өдөр тутамдаа бусад улс орнуудын залбиралын сэдвээр дамжуулан зүрхэнд минь хүрсэн Бурханы нигүүлсэлд талархъя.

Он дуусах дөхөж байгаа энэ үед амьдрал бэлэглэгч үгс, зүрхийг хөдөлгөсөн, талархал, ерөөлөөр дүүрэн үгсийг хуваалцаарай. Бидний амаар хэлсэн бүх үгс, зүрхээрээ бяс алгасан бүх зүйл Бурханыг магтахад хүргэнэ гэдэгт итгэлтэй байна..



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Монгол улсын ганц бие эхчүүд болон хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд санхүүгийн хүндрэлтэй тулгарч байна. Бурхан тэднийг гэр бүлээ тэжээх нөөц боломж, сургалт, ажилтай болох болтугай. (Сургаалт үгс 31:17)

2. Эзэн минь, Нигерт эмэгтэйчүүдийн эх барих болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж хангалтгүй байдлаас болж шаналж буй бүх эмэгтэйчүүдэд эдгэрэл, тайвшрал, хүч чадлыг өгөөч. (Марк 5:34)

3. Эзэн минь, Уругвайн сүмүүд эмзэг нөхцөлд байгаа цагаач эмэгтэйчүүдийг дэмжиж, тэдэнд сүнслэг

удирдлага өгөхөд бэлтгэгдсэн байг. Таны хайр таны хүмүүсээр дамжин харагдах болог. (1 Иохан 3:17–18)

4. Танзанийн эцэг эх бүр охидыхоо боловсролын хөгжилд анхаарч, түүний биелэлтийг хардаг байх болтугай. (Сургаалт үгс 18:15)

5. Эзэн минь, Румыны эмэгтэйчүүд Өөрт тань үнэ цэн, хэн болохоо мдэх болтугай. Тэд Таны хүслийг мэдэж, өөрийгөө Таны нүдээр харж амьдрах болно. (2 Коринт 5:17)

6. Өмнөд Солонгост 20-иос дээш насны эмэгтэйчүүдийн 64% нь гэрлэх хүсэлтэй байдаг. Сүм чуулганууд гэрлэлтийн өмнөх хөтөлбөрүүдийг зохион байгуулж, хосуудыг гэрлэлтийн амьдралд бэлтгэх болтугай. (Эхлэл 2:24)

7. Эзэн минь, Нигерийн эмэгтэйчүүд засгийн газрын бүхий л түвшинд шийдвэр гаргах чухал албан тушаалд ажиллах боломжийг олгох хууль тогтоомж батлагдан хэрэгжих болтугай. (Исаиа 22:22)

8. Бурхан минь, Мавритани охид сургалтад хамрагдах боломжийг хааж буй хүүхдийн гэрлэлт болон соёлын саадыг арилгаж, тэд мэдлэг, ур чадвар эзэмшин ирээдүйдээ итгэлтэй болох боломжийг нээж өгөөч. (Сургаалт үгс 1:5)

9. Нидерландын өөрийгөө буруугаар хардаг, хооллолтын эмгэгтэй охидод эдгэрэл авчирч, Бурханы нүдээр ямар үнэтэй болохыг харах нүдийг нь нээгээч. (Исаиа 43:4)

10. Хятад эмэгтэйчүүдэд аюулгүй, шударга, хөдөлмөр эрхлэлтийн боломж олгооч, Эзэн минь. Цалингийн ялгааг арилгаж, ялгаварлал дуусч, тэдний авьяас бүрэн үнэлэгдэн шагнагдах болтугай. (Сургаалт үгс 16:3)

11. Доминикан улсын ахимаг насны христэд итгэгч эмэгтэйчүүд залуу үеэ Бурханы Үгийг тунгаан бодохын үнэ цэнийг зааж, чиглүүлэх болтугай. (Иошуа 1:8)

12. Японд эмэгтэйчүүд улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэндийн салбарт тэгш бус байдалтай тулгардаг. Хүмүүс сайн мэдээг хүлээн авч, Библийн үнэт зүйлсийг баримтласнаар ялгаварлал дуусах болтугай. (Сургаалт үгс 2:6–10)

13. Эзэн минь, Мали улсын сонсогчдын бүлгүүдэд буй нөхөрлөлийг талархан өргөж байна. Энэ бүлгүүдийг сүнслэг өсөлт, сэтгэлзүйн дэмжлэг үзүүдэх газар болгон ерөөгөөч. (Матай 18:20)

14. Финландын эмэгтэйчүүд боловсролын эрх чөлөө болон эдийн засгийн олон боломжтой байдаг талархъя. (Дуулал 143:1)

15. Парагвай дахь эмэгтэйчүүдэд ажлын байр бий болгох стратеги, байгууллагын хамтын ажиллагаа бий болох болтугай. (Дуулал 90:17)

16. Эсватинийн эмэгтэйчүүд сүнслэг бэлгээ ашиглан бие биенээ дэмжиж, ачааг нь үүрэлцэх болтугай. (Галат 6:2)

17. Нигерийн эдийн засгийн бэрхшээлтэй нүүр тулсан эмэгтэйчүүдэд ажил, тогтвортой орлого олдоход Та туслаач. Тэдний нөөцийг нээн гэр бүлээ тэжээх боломжоор хангаач. (Дэд хууль 28:12)

18. Гана улсын эмэгтэйчүүд Таны дүрээр бүтээгдсэн гэдгийг ойлгож, нийгмийн саадыг даван туулах хүчтэй болгооч. (Эхлэл 1:27)

19. Төв Африкийн Бүгд Найрамдах Улсын бичиг үсэг тайлагдаагүй, сургуульд явах хүсэлгүй охидын нүдийг нээж, илүү ирээдүйгээ гэрэлтэйгээр харах боломжоор ерөөгөөч. (Номлогчийн үгс 7:12)

20. Кот-д’Ивуарын эмэгтэйчүүд чанартай боловсрол, тэгш мэргэжлийн боломжийг бий болгож, өөрсдийн бүрэн чадамжаа хөгжүүлэх хаалгыг нээгээч. (Сургаалт үгс 4:7)

21. Хятадын эмэгтэй хүн бүрт чанартай эрүүл мэндийн тусламж хүрэх болтугай. Ээж, охидыг бүх аюулаас хамгаалж, бие, сэтгэл, гэр бүлд нь эрүүл мэндийг хамгаалаач. (3 Иохан 1:2)

22. Хойд Кавказын эмэгтэйчүүд үнэ цэнтэй гэдгээ олж харан, өөрийн үнэлэмжийг эрүүлээр харж, үнэнч, итгэлтэй амьдрах болтугай. (Сургаалт үгс 31:25)

23. Буркина Фасогийн эмэгтэйчүүдэд зориулсан бичил зээл, сургалт, бизнесийн санаачлагуудыг ерөөж байгаад Танд талархъя. (Колоссай 3:23–24)

24. Албани улсы багийнхнаар дамжуулан Библи судалж, амьдрах ур чадвар сурч буй эмэгтэйчүүдийн итгэл, ойлголтыг өсгөж өгөөч, Бурхан минь. (Ефес 3:16–19)

25. Занзибар болон Пембагийн залбирлын үйлчлэгчдэд мэргэжлийн сургалтын бүтээлч санаа, тэдний амьжиргаанд хэрэг болох орлогын эх үүсвэрийг нээж өгөөч. (Сургаалт үгс 2:6)

26. Бениний эмэгтэйчүүд эцэг эх, нөхрийнхөө учруулсан сэтгэлийн шарх, шударга бус байдлаас үүдсэн гэмтэл, өөрийгөө үл үнэлэх байдлаас эдгэрэх болтугай, Эзэн минь. (Дуулал 139:14)

27. Бонэйр дахь христэд итгэгч эмэгтэйчүүд бие биедээ Бурханаас ирсэн амь өгөгч нөхөрлөлийг харуулж, аюулгүй, дулаан хамт олон байх болтугай. (Номлогчийн үгс 4:9–10)

28. Умард Нигерид эмэгтэйчүүдэд зориулсан насанд хүрэгчдийн боловсролын төв, ажлын байр бий болгох санаачлагыг эрх мэдэлтнүүдэд дэмжих болтугай. (Филлипой 4:3)

29. Японы эмэгтэйчүүд гэр бүл, ажил, амьдралын олон талын ачааг үүрдэг. Тэд Есүс дотор итгэл найдвар, баяр хөөрийг олж, амьдралын бүх талд цэцэглэн хөгжих болтугай. (Ром 15:13)

30. Монголын хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд ихэвчлэн боловсролын боломж дутмаг байдаг. Тэд мэдлэг, өөртөө итгэх итгэлдээ өсөж, өөрийнхөө нийгэм, манлайлагчид болох боломж нээгдэх болтугай. (Сургаалт үгс 19:20)

31. Өмнөд Солонгост эмэгтэйчүүдийн цалингийн зөрүүний асуудал шинэчлэгдэж, шударга байдал тогтох болтугай. (Дэд хууль 25:15)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. 2026 оны төлөвлөгөө Эзэний хүслийн дагуу сайн төлөвлөгдөхийн төлөө
2. Залбиралын бүлгүүд илүү идэвхитэй байж, хүнээр болон сүнсээр өсөхийн төлөө.

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.